

БАТЛАВ.



И. БАТХҮҮ
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Зөвлөх үйлчилгээний ажлын удирдамж
Мэдээлэл, технологийн мэргэжилтэн
(дотоод, 19 хүн/сар, үргэлжилсэн)

1. Ажлын байрны зорилго, зорилт

Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол Улсад L3936-MON: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг (ЭЗХАБ) хөгжүүлэх төслийг хэрэгжүүлж байна. Хэрэгжүүлэгч байгууллага нь Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ), гүйцэтгэгч агентлаг нь Барилга, хот байгуулалтын яам болон Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба юм. Төслийн хүрээнд мэдээллийн технологийн шийдэлд суурилсан Замын-Үүд чөлөөт бүсийн боомтын нэвтрэх системийг байгуулах зорилготой юм.

Энэхүү зорилтын хүрээнд улсын хэмжээний Хилийн удирдлагын нэгдсэн системийг (ХУН) бий болгож хэрэгжүүлэх явдал юм. Үндэсний хэмжээний ХУН систем нь хилийн аюулгүй байдлын өндөр түвшнийг хангахын зэрэгцээ худалдааг хөнгөвчлөх, хил дамнасан эрүүл мэндийн эрсдэлийг бууруулж, нийгмийн аюулгүй байдал, хяналт шалгалтын түшинг:

- (i) Зорчигчид;
- (ii) Тээврийн хэрэгсэл; болон
- (iii) Бараанд нэгэн зэрэг нэмэгдүүлэх зорилготой.

Үндэсний хэмжээний ХУН систем нь хилийн менежмент болон доорх байгууллагуудын систем хоорондын өгөгдөл солилцох чиглэлээр агентлаг хоорондын уялдаа холбоог бий болгохыг дэмжих зорилготой юм. Үүнд:

- (i) Сангийн яам, Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын: Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем (ГАМС);
- (ii) Хууль зүй, дотоод хэргийн яам:
 - а. Хил Хамгаалах Ерөнхий Газар: Хил хамгаалалтын бүртгэл, хяналтын систем (BPRCS, Ex-BOREX);
 - б. Монгол Улсын Гадаадын иргэн харьяатын алба: Гадаадын иргэдийн нэгдсэн систем (IFS);
- (iii) Эдийн засаг, хөгжлийн яам болон
- (iv) Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба болон Чөлөөт бүсийн захирагчийн алба болон олон улсын нисэх онгоцны буудлын бүртгэлийн алба.

Хилийн удирдлагын нэгдсэн систем нь эдгээр байгууллагуудын хоорондын болон систем хоорондын өгөгдөл солилцох боломжийг хангах үүднээс тэдгээрийн хэрэглээний програмчлалын интерфэйсээр дамжуулан Төрийн мэдээллийн ХУР сүлжээг ба бусад системүүд тухайлбал Гадаад худалдааны цахим нэг цонх зэргийг (FTSEW - Project ADB / RIBS) ашиглах, мөн хэрэв шаардлагатай гэж үзвэл E-Mongolia-г оролцуулан) Мэдээллийн Технологийн (МТ) нэг систем болгож нэгтгэн шинэчлэх хэрэгтэй.

2. Ажлын цар хүрээ

Хилийн нэгдсэн удирдлагын мэдээллийн систем хариуцах Мэдээлэл технологийн мэргэжилтэн нь улсын хэмжээнд ХУН системд хамааралтай байгууллага хоорондын уялдаа холбоо, систем хоорондын өгөгдлийн стандартчилал, өгөгдөл солилцох ажлыг хангахын тулд хилийн агентлагууд болон тэдгээрийн мэдээллийн технологийн компаниудын ажлын үр дүнг зохицуулалтаар хангаж ажиллана. ХУН системийг эхний ээлжид Замын-Үүд чөлөөт бүсэд дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- Дэлгүүрүүдийн борлуулалтын цэг дэх программ хангамжийн мэдээллийг солилцох

3. Гүйцэтгэх үндсэн үүрэг, хүлээгдэж буй үр дүн

Нарийвчилсан үүрэг даалгаварт дараах зүйлс орох боловч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Дижитал бүтээгдэхүүнийг ХУН системийн ажлын хэсэг болон Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтай уялдуулж, Замын-Үүд чөлөөт бүсэд ХУН системийн хэрэгжилтийг хангах, үүнд туршилтын төслийн сургалт семинар, чадавх бэхжүүлэх сургалтыг зохион байгуулах
- Төсөл хэрэгжүүлэх нэгж, ХУН систем, Task Force, МТ-ийн компаниуд зэрэг ХУН системийн оролцогч талуудын тайланг боловсруулах, зөвлөмж өгөх, бүтээгдэхүүн нийлүүлэх зэрэгт хяналт тавьж ажиллах
- ХУН системийн шаардлага, гэрээний үүрэг хоорондын нийцэл, ХУН системд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд МТ-ийн компаниудын бүтээгдэхүүн нийцэл/эсвэл хөгжүүлэлтэд хяналт тавих
- Хил хяналтын байгууллагуудын боловсруулсан ХУН модулиудын техникийн нийцтэй байдалд хяналт тавих;
- Үндэсний хэмжээнд дижитал ХУН системийн шаардлагыг Монгол Улсын хууль тогтоомж, Замын-Үүд чөлөөт бүсийн эрх зүйн удирдамжтай нийцүүлэн эрх зүйн зохицуулалтад оруулахад дэмжлэг үзүүлэх
- Шаардлагатай худалдан авалтад туслах: ж.нь. Мэдээллийн технологийн компани, техник хангамжийн худалдан авалт
- Андройд болон вэб хөгжүүлэх сайн туршлага, өгөгдөл/системийн стандартчилал, өгөгдөл хуваалцах, нэгтгэх сайн туршлагыг нэвтрүүлэх
- Мэдээллийн технологийн компани болон ХУН системийн ажлын хэсгийн гаргасан үр дүн, тайлан, санамж бичиг, сургалтын материал, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааны үр дүнг хянаж, үнэлэх
- Техникийн бүх зурвас, баримт бичгийг ТХН ХУН системийн хамтрагч талуудад үнэн зөв, бодитой мэдээлэл өгч байгаад хяналт тавих
- Үйл ажиллагаатай холбоотой хуралд ТХН-ийн багийг боломжтой эсвэл шаардлагатай үед төлөөлөх
- Төслийн захирал болон зохицуулагчаар дамжуулан төсөл хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгч байгууллагуудын өгсөн бусад үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэх

4. Тавигдах шаардлага:

- Мэдээллийн технологийн чиглэлээр бакалавраас доошгүй зэрэгтэй байх
- Мэдээллийн системийн чиглэлээр мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Мэдээллийн солилцоо бүхий томоохон мэдээллийн системийг хөгжүүлэх, байгуулах чиглэлээр 3-аас доошгүй жилийн мэргэжлийн туршлагатай байх
- Ур чадварын хувьд:
 - Хэрэглээний програмчлалын интерфэйс болон бичил үйлчилгээ
 - Өгөгдлийн сан, өгөгдлийн бүтэц, өгөгдлийн стандартчилал, өгөгдөл солилцох, алгоритмын мэдлэгтэй байх
 - Програмчлалын хэлний мэдлэг: о Java / PHP эсвэл ижил төстэй, HTML/CSS/JS;
 - Мэдээллийн сан: MariaDB / MySQL / PostgreSQL эсвэл үүнтэй төстэй;
 - Вэбийн аюулгүй байдлын зарчим, сайн туршлагатай байх
- Доорх шаардлагыг давуу тал гэж үзнэ. Үүнд:
 - Хилийн агентлагууд болон чөлөөт бүсэд ажиллаж байсан мэргэжлийн туршлага
 - Биометрикийн талаарх мэдлэгтэй байх
- Харилцааны болон зохион байгуулах өндөр ур чадвартай, журам ба техникийн баримт бичгийн төслийг боловсруулах чадвартай байх
- Англи хэлний чөлөөтэй ярих бичих чадвартай байх

Ерөнхий туршлага, хамгийн багадаа: 8 жил

Мэргэшсэн туршлага (даалгавартай холбоотой): 5-8 жил

| Томилолтын байршил: | Календарийн хоног: | Хугацаа: | |
|---------------------|--------------------|------------------------|--|
| Улаанбаатар хотод: | | | |
| УБ оффис | | | |
| Дорноговь аймагт: | | | |
| Замын-Үүд сум | | | |
| | | | |
| | | | |
| Нийт: | | 403 хоног / 19 хүн/сар | |

Гэрээний төрөл: үргэлжилсэн, цаг хугацаанд суурилсан